

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/5/СТА-ТБОӨААН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	2
	2.1. Оршил	3
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	3
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	7
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.11. Шилэн дансны мэдээлэл	9
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
	3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	12
	3.2. Дотоод хяналтын талаар	12
	3.3. Бараа материалын худалдан авалтын талаар	13
	3.4. Орлого, зардлын талаар	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	15
	4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	15
	4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	17
	4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	18
	4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	19
	4.5 2018 оны уулын ажил, үйлдвэрлэлийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	21
5	Зөрчлийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ШИВЭЭ-ОВОО” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ЭНХТҮВШИН ТАНАА

2019.03.15 № 06/455
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шивээ-овоо” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Шивээ-овоо” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Шивээ-овоо” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1. Оршил

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Шивээ-Овоо” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газрын захиалгаар “Пантер Мидланд Аудит” ХХК аудитыг хийж гүйцэтгэлээ.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг “Пантер мидланд аудит” ХХК-ийн аудитор Д.Билэгсайхан, Ц.Алтанцэцэг, аудиторын туслах Г.Халиунаа, Т.Алтантуяа, А.Оюунчимэг, Б.Батбаяр нар хэрэгжүүлэв.

“Шивээ-Овоо” ТӨХК нь 2018 оны санхүүгийн тайланг 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 3/238 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт, 3/237 тоот албан “Пантер мидланд аудит” ХХК-д тус тус ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

"Шивээ Овоо" ТӨХК нь байгаль орчинд сөрөг нөлөө учруулдаггүй, дэлхийн түвшинд хүрсэн тэргүүний техник технологийг түшиглэж, хэрэглэгчдийн эрэлт шаардлагад бүрэн нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн зэрэгцээ төрийн болон хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үр ашигтай шударга бизнес эрхэлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны чиглэл 101000: Чулуун нүүрс олборлолт

Туслах үйл ажиллагааны чиглэл:

Үйл ажиллагааны чиглэл 521100: Өргөн хэрэглээний барааны дэлгүүр

Үйл ажиллагааны чиглэл 552000: Гуанз, цайны газрын үйлчилгээ

Үйл ажиллагааны чиглэл 154100: Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/
- Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжид мөрдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”,
- Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар
- Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Шивээ-овоо” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 24 дүгээр тогтоол “2018 оны бизнес төлөвлөгөө”-г батлах тухай
- “Шивээ-овоо” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоол “Компанийн эзэмшлийн орон сууц хувьчлах бэлтгэл ажлыг зохион байгуулах тухай”
- “Шивээ-овоо” ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 14 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 132 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай”
- “Шивээ-овоо” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоол “ ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдүүнийг шинэчлэх батлах тухай”
- “Шивээ-овоо” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 17 дугаар тогтоол “ Нүүрсний үнийг шинэчлэн тогтоох тухай”
- “Шивээ-овоо” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 18 дугаар тогтоол “2018 оны бизнес төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай”
- “Шивээ-овоо” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 19 дүгээр тогтоол “Зээл авах зөвшөөрөл олгох тухай”
- “Шивээ-овоо” ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 21 дүгээр тогтоол “2018 оны бизнес төлөвлөгөөнд тодотгол оруулах тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2016 онд "Голден пэйж аудит" ХХК-иар боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрддөг. Энэ нь "Эрдэнэс Монгол" ХХК-иас боловсруулан өгсөн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй нийцээгүйгээс гадна шинээр авсан санхүүгийн програмтай уялдаагүй байна.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Шивээ-овоо" ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Silicon 3.0" программ хангамж ашигладаг байна.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад "Шивээ-Овоо" ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь, аудитын эрсдэлийг тодорхойлоход санхүүгийн тайлангуудыг материаллаг байдлаар алдаатай илэрхийлэгдсэн байж болзошгүй гэж сонгосон болно.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн 2018 оны нийт зардал 53,958.8 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 1,079.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь санхүүгийн тайлангийн хувьд аудитын эрсдэлийг зохистой жишгээр тогтоохтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, "Шивээ-Овоо" ТӨХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Бараа материал
- Урьдчилж гарсан зардал болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	9,125.60	Шууд худалдан авалтаар 8,354.5 сая төгрөг, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй 771.1 сая төгрөг
	Дүн	4	9,125.60	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Шивээ-Овоо” ТӨХК-д дараах анхаарал татахуйц чухал асуудлууд байна. Үүнд:

- ✓ Дотоод аудитын нэгжгүй
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй.
- ✓ Монгол Улсын Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээ /MON-P4, MON-P5/-ээр авсан урт хугацаат зээл, хүүгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулсан.

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөшгин шалгах шаардлагатай дараах дансдууд байна. Үүнд:

- ✓ Урьдчилж гарсан тооцоо, зардал
- ✓ Авлага, өглөгийн тооцоололт, түүний барагдуулалт
- ✓ Худалдан авалт, тендер
- ✓ Техник тоног төхөөрөмжийн сэлбэгийн орлого, зарцуулалт
- ✓ Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад татварын тооцоололт зэргийг дахин нягталж үзэх шаардлагатай.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт дараах байдалтай байна.

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2018 оны төлөвлөгөө	2018 оны төлөвлөгөө /тодотгол/	2018 оны гүйцэтгэл	Харьцуулалт	
						%	Мөнгөн дүн
А. Уулын ажлын үзүүлэлт							
1	Нүүрс олборлолт	м.тн	2,000.0	2,000.0	2,000.7	100.0	0.7
2	Нүүрс борлуулалт	м.тн	2,000.1	2,000.1	1,964.3	98.2	(35.8)
3	Тээвэртэй хөрс хуулалт	м.м ³	6,417.9	6,417.9	4,915.6	76.6	(1,502.3)
4	Тээвэргүй хөрс хуулалт	м.м ³	2,047.6	2,047.6	2,049.7	100.1	2.1
5	Дахин шидэлт	м.м ³	2,839.7	2,839.7	1,810.7	63.8	(1,029.0)
6	Нийт хөрс хуулалт	м.м³	8,465.5	8,465.5	6,965.3	82.3	(1,500.2)
7	Инженер ажил	м.м ³	1,381.5	1,381.5	595.0	43.1	(786.5)

“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

8	Нийт уулын цул	м.м³	13,359.1	13,359.1	11,024.5	82.5	(2,334.6)
---	----------------	------	----------	----------	----------	------	-----------

2018 оны уулын ажлын төлөвлөгөөнд 2,000.0 мянган тонн нүүрс олборлож борлуулахаар тооцсон байна. Тайлант хугацаанд 2,000.7 мянган тонн нүүрс олборлож борлуулсан байна. Энэ нь өмнөх жилээс 0.1 хувиар буурч, төлөвлөснөөс 0.04 хувиар нэмэгдсэн байна.

Нийт орлого, зардлын бүтэц:

Үзүүлэлтүүд	2017 оны гүйцэтгэл	2018 оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт орлого	51,877,304.90	52,060,886.40	51,289,765.20
Үндсэн үйл ажиллагааны орлого	49,373,804.60	51,916,386.40	50,777,682.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,503,500.30	144,500.00	105,143.10
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			444,061.60
Ханшийн зөрүүний алдагдал			(37,121.50)
Нийт зардал	51,351,882.60	53,632,930.20	53,921,436.20
Борлуулсан барааны өртөг	41,751,249.10	49,355,010.30	47,891,507.40
Борлуулалт маркетингийн зардал	1,493,640.00	0.00	1,109,252.00
Ерөнхий удирдлагын зардал	3,832,462.20	3,176,309.40	2,302,127.10
Үйл ажиллагааны бусад зардал	557,611.00	1,101,610.50	2,179,008.30
Санхүүгийн зардал	3,653,420.70	0.00	436,309.50
Ханшийн зөрүүний алдагдал	0.00	0.00	0.00
Татварын зардал	63,499.60	0.00	3,231.90
АШИГ	525,422.30	(1,572,043.80)	(2,631,671.00)

Тайлант жилд нийт борлуулалтын орлого 51,289.7 сая төгрөг. Үүнээс үндсэн үйл ажиллагаанаас 50,777.7 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 105.1 сая төгрөг, үндсэн хөрөнгө данснаас хассаны олз 444.1 сая төгрөгийн орлого тус тус олсон байна.

Нийт орлого өмнөх оноос 587.5 сая төгрөг буюу 1.1 хувиар, төлөвлөснөөс 771.1 сая төгрөг буюу 1.5 хувиар буурсан байна. Орлого буурсан шалтгаан нь жингийн болон илчлэгийн зөрүүнээс үүссэнтэй холбоотой.

Нийт зардал 53,921.4 сая төгрөгт хүрч өмнөх оноос 2,569.5 сая төгрөг буюу 5.0 хувиар өссөн, төлөвлөснөөс 0.5 хувиар буюу 288.5 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Тайлант жилд 1,572.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөж, 2,631.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдалтай ажилласан шалтгаан нь 2018 онд түлш, шатахууны үнэ нэмэгдсэнээс гадна урт хугацаат зээлийн хүүг тооцоолж тусгасантай холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу www.shilendans.gov.mn-д хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 6 төрлийн мэдээллийг оруулсан байна.

Байгууллагын цахим хуудсанд компанийн мэдээлэл, холбогдох журам, заавар, нийгмийн хариуцлагын талаар хийсэн ажил, үйл ажиллагааны цаг үеийн мэдээ, мэдээллийг оруулсан байна.

“Шивээ-Овоо” ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

“Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд “Пантер мидланд аудит” ХХК-ийн хийсэн аудитаар 5 зөвлөмж, 3 албан шаардлага өгөгдсөн бөгөөд эдгээр зөвлөмжөөс бүрэн биелсэн 4, хэрэгжих шатандаа 1 зөвлөмж байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна. Шүүхийн шийдвэр гарсан боловч эзэн холбогдогч нь олдохгүй авлагын асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бөгөөд 2019 оны 3 дугаар сард багтаан шийдвэрлэхээр төлөвлөж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Шивээ-Овоо” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Шивээ-Овоо" ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Шивээ-Овоо" ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

“Шивээ овоо” ТӨХК нь 2016 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг /НБББББ/ хийлгүүлэн мөрдөж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг судлах явцад дараах зүйл ажиглагдсан.

1. Үндэслэл болгосон баримт бичгүүдээс хэд хэдэн СТОУС шинээр гарсан, өөрчлөгдсөн байна. Тухайлбал: Орлогын стандартыг 2018 оны 1 дүгээр сараас шинээр мөрдөж эхэлсэн.
2. Авлагын насжилтыг тооцож, борлуулалтын орлогын дүнгээс тодорхой хувиар найдваргүй авлагын нөөц тооцно гэж тусгасан боловч тооцоогүй байна.
3. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд шаардлагатай тусгайлсан журмуудыг НБББББ-тээ тусгаж өгөх шаардлагатай байна. Тухайлбал: Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцох тусгайлсан журам байхгүй бөгөөд компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран элэгдэл тооцох тусгайлсан бодлого зайлшгүй шаардлагатай байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх, тохиромжтой бодлого хэрэглээгүйгээс компани алдагдалд орох, үйл ажиллагааны доголдол үүсэх эрсдэлтэй.

Батламж мэдэгдэл: (үнэн зөв байх, үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх)

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх.

Шаардлагатай журмуудыг шинэчлэн боловсруулж батлах, тухайлбал: хөрөнгийн ашиглалт, шинж чанарыг харгалзан үзэж элэгдүүлэх, элэгдлийн бодлогоо тодорхойлсон элэгдэл тооцох журам боловсруулах.

3.1.4 Үйлчлүүлэгчийн харуу:

Компанийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

3.2. Дотоод хяналтын талаар

3.2.1 Илрүүлэлт:

Тус компани нь дотоод хяналтын нэгжгүй ажиллаж байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.3 дахь заалтуудыг зөрчсөн байгаа нь дотоод хяналтыг сулруулах, үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангахгүй байх нь компанийн үйл ажиллагаанд буруу менежмент хийх эрсдэлтэй.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.3 дахь заалтуудыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.2.4 Үйлчлүүлэгчийн хариу:

Компанийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

3.3. Бараа материалын худалдан авалтын талаар

3.3.1 Илрүүлэлт:

“Шивээ-овоо” ТӨХК нь 2018 онд шууд худалдан авалтаар 8,354.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Чанаргүй бараа материал нийлүүлсэн, гэрээнд заасан хугацааг хэтрүүлсэн 10 газрын гэрээг цуцалсан байна. Худалдах, худалдан авах гэрээнд зарим албан тушаалтны гарын үсэг дутуу, харьцуулалтын тендерийн үнийн санал хүргүүлсэн албан бичиг дутуу гэх мэт зөрчлүүд байна.

3.3.2 Эрсдэл:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтыг мөрдөж, тендер зохион байгуулаагүйгээс зах зээлийн үнээс өндөр үнээр бараа материалыг худалдан авч үргүй зардал гаргах, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээх эрсдэлтэй.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг жилээр төлөвлөж, зохих журмын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах.

3.3.4 Үйлчлүүлэгчийн хариу:

Компанийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

3.4. Орлого, зардлын талаар

3.4.1 Илрүүлэлт:

Тайлант жилд нийт борлуулалтын орлого 51,289.7 сая төгрөг. Үүнээс үндсэн үйл ажиллагаанаас 50,777.6 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагаанаас 549.1 сая төгрөгийн орлого тус тус олсон байна. Нийт орлого өмнөх оноос 587.5 сая төгрөг буюу 1.1 хувиар, төлөвлөсөнөөс 771.1 сая төгрөг буюу 1.4 хувиар буурсан байна.

Нийт зардал 53,921.4 сая төгрөгт хүрч өмнөх оноос 2,569.5 сая төгрөг буюу 17.2 хувиар, төлөвлөсөнөөс 5.0 хувиар буюу 288.5 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

3.4.2 Эрсдэл:

Төлөвлөгөөг оновчтой хийгээгүйгээс хэтийн зорилтыг буруу тодорхойлох эрсдэлтэй.

Батламж мэдэгдэл: (Эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал)

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд, компанийн дүрэмд заасныг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.4.4 Үйлчлүүлэгчийн харуу:

Компанийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2018.01.01	2018.12.31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	815 127 904,04	1 357 313 468,20
Дансны авлага	6 198 433 095,04	7 368 110 746,21
Татвар, НДШ-ийн авлага	994 836 177,32	0,00
Бусад авлага	229 447 407,73	663 639 723,61
Бусад санхүүгийн хөрөнгө/ НА хасагдуулга/	-3 191 012 968,00	-3 191 012 968,00
Бараа материал	13 558 722 650,87	14 639 936 260,41
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	3 341 574 510,83	4 058 490 155,81
Бусад эргэдтийн хөрөнгө		0,00
Борлуулах зоилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө / борлуулах бүлэг хөрөнгө/	0,00	0,00
Эргэлтийн хөрөнгийн дүн	21 947 128 777,83	24 896 477 386,24
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	63 294 939 428,62	66 807 487 688,67
Биет бус хөрөнгө	30 105 642,78	27 500 000,00
Хойшлогдсон хөрс хуулалтын шавхагдал	-2 056 467 925,00	-2 674 133 497,20
Урт хугацаат хөрөнгө оруулалт	500 025 752,62	530 131 395,42
Хайгуул ба үнэлгээний тайлан	0,00	0,00
Хойшлогдсон татварын хөрөнгө	0,00	0,00
Хөрөнгө оруулалтын зориулалтай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1 306 537 193,78	1 066 825 493,78
Капиталжуулсан хөрс хуулалт	31 173 428 322,61	34 287 341 156,40
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	94 248 568 415,41	100 045 152 237,07
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	116 195 697 193,24	124 941 629 623,31
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	22 485 866 580,58	30 719 664 377,78
Цалингийн өглөг	396 497 017,11	729 129 375,66
Татварын өглөг	2 592 782 333,30	4 224 930 865,34
НДШ-ийн өглөг	299 496 292,96	877 244 396,29
Богино хугацаат зээл		1 499 999 999,98
Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг	5 198 808 779,00	

“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Засгийн газрын дэмжлэг	2 193 778 389,73	
Ногдол ашгийн өглөг	13 041 910,10	13 041 910,10
Урьдчилж орсон орлого	12 219 005,47	36 772 504,49
Санхүүгийн түрээсийн өглөг		
Бусад богино хугацаат өр төлбөр	30 040 197 668,93	5 722 819 354,36
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө/ борлуулах бүлэг хөрөнгө/-нд хамаарах өр төлбөр	0,00	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	63 232 687 977,18	43 823 602 784,00
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	13 937 326 403,09	2 354 027 050,71
Засгийн газрын дэмжлэг	20 392 768 723,00	59 195 878 218,04
Ажилчдын тэтгэвэрийн сан	1 373 207 370,63	1 343 643 750,00
Санхүүгийн түрээсийн өглөг	10 297 427 085,26	13 049 041 059,36
Санхүүгийн түрээсийн хүүгийн өглөг		
Хойшлогдсон татварын өр	358 564 643,00	358 564 643,00
Урт хугацаати өр төлбөрийн дүн	46 359 294 224,98	76 301 154 721,11
Өр төлбөрийн нийт дүн	109 591 982 202,16	120 124 757 505,11
Эздийн өмч		
өмч: - төрийн	1 207 710 000,00	1 207 710 000,00
- хувийн	134 190 000,00	134 190 000,00
- хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	5 261 814 991,08	3 474 972 118,20
Эзэмшигчдийн өмчийн дүн	6 603 714 991,08	4 816 872 118,20
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	116 195 697 193,24	124 941 629 623,31

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлого	50 359 237 159,66	50 777 682 082,66
Борлуулалтаас буцсан хорогдол	-985 432 545,70	
Цэвэр борлуулалт	49 373 804 613,96	50 777 682 082,66
Борлуулалтын өртөг	41 751 249 100,58	47 891 507 435,49
Нийт ашиг (алдагдал)	7 622 555 513,38	2 886 174 647,17
Түрээсийн орлого	1 443 704 986,30	
Хүүний орлого	18 548 234,55	32 870 099,38
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого	1 041 247 175,31	72 272 959,77
Борлуулалт маркетингийн зардал	1 493 640 023,21	1 109 252 077,52
Ерөнхий ба удирдлагын зардал	3 832 462 273,03	2 302 127 147,62
Санхүүгийн зардал	3 653 420 753,47	436 309 520,50
Бусад зардал	557 611 061,43	2 179 008 359,32
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		-37 121 591,38
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		444 061 653,11
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0,00	
хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0,00	
Бусад ашиг (алдагдал)	0,00	
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	588 921 798,40	-2 628 439 336,91
Орлогын татварын зардал	63 499 649,15	3 231 941,36
Татварын дараах ашиг (алдагдал)	525 422 149,25	-2 631 671 278,27
Зогссон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	525 422 149,25	-2 631 671 278,27
Бусад дэлгэрэнгүй орлого	0,00	0,00
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0,00	
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00
Бусад олз (гарз)	0,00	
Орлогын нийт дүн	525 422 149,25	-2 631 671 278,27
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	0,00

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1 341 900 000,00	5 261 814 991,08	6 603 714 991,08
Нятлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		0,00	0,00
Залруулсан үлдэгдэл	1 341 900 000,00	5 261 814 991,08	6 603 714 991,08
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал			0,00
Бусад дэлгэрэнгүй орлого			0,00
Өмчид гарсан өөрчлөлт			0,00
Зарласан ногдол ашиг			0,00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			0,00
2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1 341 900 000,00	5 261 814 991,08	6 603 714 991,08
Нятлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга		844 828 405,39	844 828 405,39
Залруулсан үлдэгдэл	1 341 900 000,00	6 106 643 396,47	7 448 543 396,47
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		-2 631 671 278,27	-2 631 671 278,27
Бусад дэлгэрэнгүй орлого			0,00
Өмчид гарсан өөрчлөлт			0,00
Зарласан ногдол ашиг			0,00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		0,00	0,00
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1 341 900 000,00	3 474 972 118,20	4 816 872 118,20

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	213 491 979 504,97	57 996 852 755,68
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	213 358 389 692,88	53 608 854 587,22
Эрхийн шимтгэл,хураамж төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар	85 779 579,00	
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	47 810 233,09	4 387 998 168,46
Мөнгөн зарлагын дүн (-)	129 212 224 353,14	45 107 633 315,66
Ажиллагчдад төлсөн мөнгө	4 137 041 170,00	6 337 201 400,79
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	1 250 280 493,91	1 929 455 879,00
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	88 909 572 297,62	16 386 156 094,74
Ашиглалтын зардал төлсөн мөнгө	28 600 769,00	
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1 441 448,00	11 712 367 066,27
Хүүний төлбөрт төлсөн		411 479 152,66
Татварын байгууллагад төлсөн	31 574 353 880,23	2 621 942 489,28
Даатгалын төлбөрт төлсөн	105 458 878,82	69 338 632,00
Бусад мөнгөн зарлага	3 205 475 415,56	5 639 692 600,92
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	84 279 755 151,83	12 889 219 440,02
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	351 761 002,89	0,00
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0,00	
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0,00	
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0,00	
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0,00	
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0,00	
Хүлээн авсан хүүний орлого	351 761 002,89	
Хүлээн авсан ногдол ашиг	0,00	
Мөнгөн зарлагын дүн (-)	277 250 146,84	9 578 298 768,97
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	54 262 640,00	3 589 073 130,00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0,00	
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	222 987 506,84	
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	0,00	5 989 225 638,97
Ханшийн тэгшитгэлийн ашиг	0,00	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	74 510 856,05	-9 578 298 768,97
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		

“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн орлогын (+)	2 584 706 273,04	5 000 000 000,00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0,00	5 000 000 000,00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0,00	
Төрөл бүрийн хандив	0,00	
Толгой компаниас авсан зээл	0,00	
Валютын ханшийн зөрүү	2 584 706 273,04	
Мөнгөн зарлагын дүн (-)	82 241 662 433,43	7 768 735 106,89
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0,00	3 607 520 000,02
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	4 450 000,00	3 970 054 841,28
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0,00	
Төлсөн ногдол ашиг	79 641 689 491,91	
Валютын ханшийн зөрүү	2 595 522 941,52	
Буцалтгүй тусламж		191 160 265,59
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-79 656 956 160,39	-2 768 735 106,89
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4 697 309 847,49	542 185 564,16
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1 626 263 897,18	815 127 904,04
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	815 127 904,04	1 357 313 468,20

4.5 2018 оны уулын ажил, үйлдвэрлэлийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлтүүд	Хэм нэгж	2018 оны төлөвлөгөө	2018 оны төлөвлөгөө /тодотгол/	2018 оны гүйцэтгэл	Харьцуулалт	
						%	Мөнгөн дүн
А. Уулын ажлын үзүүлэлт							
1	Нүүрс олборлолт	м.тн	2,000.0	2,000.0	2,000.7	100.0	0.7
2	Нүүрс борлуулалт	м.тн	2,000.1	2,000.1	1,964.3	98.2	(35.8)
3	Тээвэртэй хөрс хуулалт	м.м³	6,417.9	6,417.9	4,915.6	76.6	(1,502.3)
4	Тээвэргүй хөрс хуулалт	м.м³	2,047.6	2,047.6	2,049.7	100.1	2.1
5	Дахин шидэлт	м.м³	2,839.7	2,839.7	1,810.7	63.8	(1,029.0)
6	Нийт хөрс хуулалт	м.м³	8,465.5	8,465.5	6,965.3	82.3	(1,500.2)
7	Инженер ажил	м.м³	1,381.5	1,381.5	595.0	43.1	(786.5)
8	Нийт уулын цул	м.м³	13,359.1	13,359.1	11,024.5	82.5	(2,334.6)
Б. Орлого, зардал, ашгийн үзүүлэлт							
1	Борлуулалтын орлого	м.төг	49,748,553.4	51,916,386.4	50,777,682.1	97.8	(1,138,704.4)
2	Үйл ажиллагааны бус орлого	м.төг	144,500.0	144,500.0	1,072,527.3	742.2	928,027.3
3	Нийт орлого	м.төг	49,893,053.4	52,060,886.4	51,850,209.4	99.6	(210,677.0)
4	Үйлдвэрлэлийн зардал	м.төг	48,786,727.7	52,531,319.7	50,991,338.3	97.1	(1,539,981.4)
5	Үйл ажиллагааны бус зардал	м.төг	1,101,610.5	1,101,610.5	1,311,534.1	119.1	209,923.6
6	Нийт зардал	м.төг	49,888,338.2	53,632,930.2	52,302,872.3	97.5	(1,330,057.9)
7	Татварын өмнөх ашиг	м.төг	4,715.2	(1,572,043.8)	(452,662.9)	28.8	1,119,380.9
8	ААНОАТ	м.төг	471.5	-	-	-	-
9	Татварын дараах ашиг	м.төг	4,243.7	(1,572,043.8)	(452,662.9)	28.8	1,119,380.9
В. Зардлын үзүүлэлт							
1	Тэсэлгээ	м.төг	3,921,412.1	3,921,412.1	3,107,325.8	79.2	(814,086.3)
2	Дизелийн түлш	м.төг	7,440,603.8	7,817,195.8	7,426,977.6	95.0	(390,218.2)
3	Бензин	м.төг	83,737.5	83,737.5	76,189.7	91.0	(7,547.8)
4	Тос, тослох материал	м.төг	800,628.5	800,628.5	840,611.9	105.0	39,983.4
5	Цахилгаан эрчим хүч	м.төг	3,400,721.0	3,400,721.0	2,633,431.9	77.4	(767,289.1)
6	Вагон ашиглалт	м.төг	235,174.2	235,174.2	384,475.2	163.5	149,301.0
7	Дулаан	м.төг	74,090.3	74,090.3	62,898.9	84.9	(11,191.4)
8	Дугуй	м.төг	1,285,620.0	2,025,620.0	381,182.7	18.8	(1,644,437.3)
9	Сэлбэг хэрэгсэл	м.төг	9,475,261.8	10,761,261.8	9,835,099.9	91.4	(926,161.9)
10	Хөдөлмөр хамгаалал	м.төг	625,756.4	625,756.4	522,552.8	83.5	(103,203.6)
11	Цалин хөлс	м.төг	8,971,540.9	8,971,540.9	8,988,354.8	100.2	16,814.0
12	НДШ	м.төг	1,166,300.3	1,166,300.3	1,443,530.5	123.8	277,230.2
13	Ашигт малтмалын төлбөр	м.төг	1,243,713.8	1,243,713.8	1,256,745.5	101.0	13,031.7
14	УАТ, ҮХХАТ, АТӨЯХАТ	м.төг	1,200,622.1	1,200,622.1	614,673.8	51.2	(585,948.2)
15	Үндсэн хөрөнгийн элэгдэл	м.төг	8,064,734.1	8,064,734.1	8,851,393.4	109.8	786,659.3
16	Зээлийн хүү	м.төг	954,373.5	954,373.5	954,373.5	100.0	-
17	Хөрс хуулалтын хойшлох зардал	м.төг	(6,339,303.2)	(6,339,303.2)	(2,496,247.3)	39.4	3,843,055.9
18	Даатгалын зардал	м.төг	170,719.7	170,719.7	219,465.0	128.6	48,745.3

“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

19	Нөхөн сэргээлтийн зардал	м.төг	137,800.0	137,800.0	100,591.6	73.0	(37,208.4)
20	Гэрээт ажлын хөлс	м.төг	1,878,990.7	3,220,990.7	2,675,555.0	83.1	(545,435.7)
21	Албан томилолт	м.төг	70,370.1	70,370.1	136,898.0	194.5	66,527.9
22	Сургалт	м.төг	88,653.0	88,653.0	48,771.4	55.0	(39,881.6)
23	Лицензийн талбайн түрээс	м.төг	-	-	224,400.0	-	224,400.0
24	Харуул хамгаалалт	м.төг	174,000.0	174,000.0	188,178.2	108.1	14,178.2
25	Бусад зардал	м.төг	817,920.9	817,920.9	1,206,030.6	147.5	388,109.7
26	Удирдлагын зардал	м.төг	2,843,286.3	2,843,286.3	1,963,885.6	69.1	(879,400.7)
27	Нийт зардал	м.төг	48,786,727.7	52,531,319.7	51,647,346.3	98.3	(883,973.4)
28	Нийт зардал болон дундаж өртгөөр тооцсон ББӨ-ийн зөрүү	м.төг	-	-	(656,008.0)	-	(656,008.0)
29	Борлуулалтын өөрийн өртөг	м.төг	48,786,727.7	52,531,319.7	50,991,338.3	97.1	(1,539,981.4)
Г. Бусад үзүүлэлт							
1	1 тн нүүрсний дундаж өртөг	төг	24,393.4	26,265.7	25,814.7	98.3	(450.9)
2	1 тн нүүрсний тайлант үеийн өртөг	төг	27,563.0	29,435.3	27,371.1	93.0	(2,064.2)
3	1 тн нүүрсний дундаж үнэ	төг	24,872.6	25,956.5	25,849.9	99.6	(106.6)
4	1 м³ уулын цулын өртөг	төг	3,651.9	3,932.2	4,684.8	119.1	752.5
5	Хөрс хуулалтын коэффициент	коэфф	4.23	4.23	3.48	82.3	(0.8)
6	Ажилчдын тоо	хүн	582	582	535	91.9	(47.0)
7	Нийт цалингийн сан	м.төг	10,849,960	10,849,960	10,054,453	92.7	(795,506.8)
8	Сарын дундаж хөлс	м.төг	1,553.5	1,553.5	1,566.1	100.8	12.6
9	Нийт авлага	м.төг	2,500,000.0	2,500,000.0	4,840,737.5	193.6	2,340,737.5
10	Богино хугацаат өглөг	м.төг	75,902,111.8	75,902,111.8	43,823,602.8	57.7	(32,078,509.0)
11	Бор-ын 1 төг-т ногдох зардал	төг	0.98	1.01	1.02	100.5	0.0
12	Төсвийн төлбөрт	м.төг	8,585,963.1	8,802,274.9	8,392,718.1	95.3	(409,556.7)
12.1	Үүнээс: а\ ААН-ОАТ	м.төг	471.5	-	-	-	-
12.2	б\ НӨАТ	м.төг	4,974,855.3	5,191,638.6	5,077,768.2	97.8	(113,870.4)
12.3	в\ бусад татвар	м.төг	3,610,636.2	3,610,636.2	3,314,949.9	91.8	(295,686.3)
13	Хөдөлмөрийн бүтээмж, орлогоор	м.төг	85,478.6	89,203.4	94,911.6	106.4	5,708.1
14	Хөдөлмөрийн бүтээмж, ажлаар	м.м³	23.0	23.0	20.6	89.8	(2.3)
Д. Биетээр							
1	Дизель түлш	литр	4,650,377	4,650,377	4,604,810	99.0	(45,567.8)
2	Бензин	литр	51,625	51,625	47,372	91.8	(4,253.0)
3	Тос, тослох материал	кг	150,866	150,866	150,789	99.9	(77.5)
4	Цахилгаан	квт	18,176,579	18,176,579	15,076,080	82.9	(3,100,498.7)
5	Тэсрэх материал	тн	2,252	2,252	1,626	72.2	(626.4)
6	Ус шүүрүүлэлт	м.куб	5,704	5,704	3,508	61.5	(2,196.2)
7	Дугуй	ш	203	203	97	47.8	(106.0)

5 Зөрчлийн нэгтгэл

Огноо:	Аудитын нэр:	“Шивээ-овоо” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.03.01			САГ-2019/5/СТА-ТБОӨААН
Шалгагдсан байгууллагын нэр:	“Шивээ-овоо” ТӨХК		сая төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
Дотоод хяналтын нэгжгүй		Зөвлөмж өгөх	Шивээ-овоо ТӨХК-ийн захирал	Ц.Энхтүвшин
Нягтлан бодох бүртгэлийн бодлогод стандартын өөрчлөлтийг тусгаагүй		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н. Энхжаргал
“Шивээ-овоо” ТӨХК нь 2018 онд шууд худалдан авалтаар 8,354.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.	8,354.5	Зөвлөмж өгөх	Шивээ-овоо ТӨХК-ийн захирал	Ц.Энхтүвшин
Нийт орлого өмнөх оноос 587.5 сая төгрөг буюу 1,14%-иар, төлөвлөснөөс 771.1 сая төгрөг буюу 1.4 %-иар буурсан байна.	771.1	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Н. Энхжаргал
Дүн	9,125.6			

